



## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.08.20-08.24

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Мэдээлэл технологи болон эрчим хүчний салбарт үйл ажиллагаагаа явуулж буй компаниудын хувьцааны ханш өссөнөөр АНУ-ын зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Иран улс газрын тосны нийлүүлэлтээ багасгаж байгаа талаар мэдээлж, газрын тосны үнэ 6 орчим хувиар өсжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч БНХАУ болон Европын холбоог өөрсдийн валютын ханшийг доогуур түвшинд барин, экспортоо тэлэх бодлого баримталж байгаад буруутгав. Мөн тэрээр Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ өсгөхгүй гэдэгт найдаж байгаагаа илэрхийллээ.

АНУ-ын нийслэл Вашингтон хотноо 2 өдрийн турш болж өнгөрсөн АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээр үр дүн багатай болж өнгөрчээ.

Баасан гарагт Холбооны нөөцийн банкны тэргүүн ноён Жером Пауэлл АНУ-ын эдийн засаг өсч, ажилгүйдлийн түвшин бага байгаа үед бодлогын хүүгээ үргэлжлүүлэн нэмнэ хэмээн мэдэгдлээ.

**Европ:** Худалдааны маргаан болон улс төрийн тодорхой бус байдлаас үл хамааран еврогийн ханш ам. долларын эсрэг чангарсан байна.

Европын бүсийн борлуулалтын менежрүүдийн индексийн (PMI) бизнесийн итгэлийн үзүүлэлт сүүлийн 23 сард үзэгдээгүй доод түвшинд хүрчээ.

Итали улс төсвийн зардлаа нэмэх талаар мэдээлснээс хойш хөрөнгө оруулагчид Итали улсын Засгийн газрын бондыг сүүлийн 2 сарын хугацаанд ихээр нь зарах болжээ. Итали улсын төсөв 10-р сарын дундуур батлагдах ажээ.

Их Британи болон Европын холбооны "Brexit" хэлцэл амжилтгүй болж, Их Британи 2019 оны 3-р сараас өмнө Европын холбооноос гарах боломжгүй болжээ. Ингэснээр фунтийн ханш ам. долларын эсрэг суларч FTSE 100 индекс тогтвортой байлаа.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагджээ. Иенийн ханш тогтвортой байж, ам.долларын эсрэг 111.3 болов.

Японы "Jiji" агентлагийн мэдээлснээр Япон улсын Батлан хамгаалах яам 2 ширхэг пуужингийн хамгаалалтын систем авах зорилгоор 5.3 их наяд иенийг 2019 оны төсөвт суулгаж өгөхийг хүсчээ. Ингэснээр 2019 оны төсвийн зардал өмнөх онтой харьцуулахад 100 тэрбум иенээр нэмэгдэх аж. Японы Батлан хамгаалах яам өөрийн газрын, усан цэргийн болон агаарын хүчний хамгаалалтаа нэмээд зогсохгүй кибер халдлагаас урьдчилан сэргийлж эхэллээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэж байгаа хэрээр Японы томоохон үйлдвэрлэгчдийн бизнесийн итгэлийг харуулдаг "Tankan" индекс сүүлийн долоон сарын дээд түвшиндээ хүрчээ. Харин тус индексийн үйлчилгээний салбарын үзүүлэлт 2016 оноос хойшхи хамгийн доод түвшинд хүрэв.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

Олон улсын индексүүд			
Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,170.64	-0.48% ▼
Dow Jones	АНУ	25,790.35	0.47% ▲
S&P 500	АНУ	2,874.69	0.86% ▲
Nasdaq	АНУ	7,945.98	1.66% ▲
S&P/TSX	Канад	16,356.05	0.20% ▲
FTSE 100	Их Британи	7,577.49	0.25% ▲
S&P/ASX 200	Австрали	6,247.30	-1.45% ▼
Nikkei 225	Япон	22,601.77	1.49% ▲
Hang Seng	Хонг Конг	27,671.87	1.68% ▲

Бондын өгөөж			
Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.30
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.27
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.64
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.26
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.37
TDBM' 2020	USD	9.3%	106.35

Зах зээлийн хүү			
Хүү	Хаалт	Өөрчлөлт	
Libor 1M	2.073	0.00	▲
Libor 3M	2.317	0.01	▲
Libor 6M	2.523	0.01	▲
Libor 1YR	2.820	0.01	▲
US 6M Bond	2.232	0.01	▲
US 2YR Bond	2.624	0.02	▲
US 3YR Bond	2.675	-0.01	▼
US 5YR Bond	2.719	-0.03	▼
US 10YR Bond	2.817	-0.05	▼

Валютын ханш /төг/			
Валют	2018.08.24	Өөрчлөлт	
USD	2,469.79	0.21%	▲
CNY	358.82	0.29%	▲
EUR	2,854.34	1.70%	▲
RUB	36.43	-1.14%	▼
KRW	2.21	0.91%	▲
JPY	22.17	-0.40%	▼

Түүхий эдийн үнэ			
Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,205.35	1.87% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.82	0.41% ▲
Зэс	USD/lb.	272.30	1.89% ▲
Нүүрс	USD/MT	107.00	-0.79% ▼
WTI газрын тос	USD/bbl.	68.72	4.42% ▲
Brent газрын тос	USD/bbl.	75.82	5.75% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.92	0.00%

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд			
Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ	
Инфляцийн түвшин	2018. VII	7.70%	
Бодлогын хүү	2018. VII	10.00%	
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VI	10.00%	
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	12.30%	
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VI	5.20%	
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	18.00%	
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VI	10.20%	

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 35 компанийн 329.1 сая төгрөгийн 2,550,852 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөх ган” /HGN/ компанийн хувьцаа 12.50%-аар буюу хамгийн ихээр өсч 90 төгрөгт хүрч хаагдсан бол “Мерекс” /MRX/ компанийн хувьцаа 12.12%-аар буурч 29 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 10,489 ширхэг үнэт цаас 1,111 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 24-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,323.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,170.64 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.48%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,440.1
Зах зээлийн үнэлгээ	2,323,494.3

### Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,170.64	-0.48% ▼
MSE I индекс	9,292.52	-0.75% ▼
MSE II индекс	9,226.12	-0.05% ▼

### Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	2,246,484	146,933,726
АПУ	112,779	65,691,495
Таван Толгой	3,593	28,850,540
Говь	1,097	27,297,340
Монгол базальт	48,476	16,884,333

### Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөх ган	90.00	12.50% ▲
Агротехимпекс	1,075.00	10.26% ▲
Багануур	1,949.00	8.28% ▲
Дархан нэхий	18,700.00	8.09% ▲
Жинст-Увс	1,505.00	3.08% ▲

### Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Мерекс	29.00	-12.12% ▼
Монгол шуудан	540.00	-10.00% ▼
Дархан зочид буудал	120.00	-7.69% ▼
ЛэндМН ББСБ	64.32	-6.80% ▼
Хай Би Ойл	57.00	-5.00% ▼

### Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	4,590,886,267
Голомт Капитал	110,674,638
Бумбат-Алтай	102,447,809
Ти Ди Би Капитал	94,394,942
БиДиСек	40,991,637

### Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	584.67	622,195
Таван толгой	8,035.00	423,165
МИК	10,980.00	227,388
Говь	24,880.00	194,092
Сүү	217.63	74,865

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-01/02-19-A0285-13.745	140	14,330,400	102,360	102,360	104	13.745%
2	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	58	5,989,080	103,260	103,260	104	15.995%
3	ZGEB-BD-10/10/19-A0336-13.945	250	25,752,500	103,010	103,010	104	13.945%
4	ZGEB-BD-11/04/19-A0230-18	338	35,189,180	104,110	104,110	104	18.000%
5	ZGEB-BD-14/03/19-A0219-18	147	15,235,080	103,640	103,640	104	18.000%
6	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	1,097	116,347,820	106,060	106,060	156	14.500%
7	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	3,920	418,969,600	106,880	106,880	156	15.140%
8	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	100	10,748,000	107,480	107,480	156	15.870%
9	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	1,640	169,100,400	103,110	103,110	104	13.955%
10	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	1,289	140,320,540	108,860	108,860	156	16.993%
11	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	1,000	102,920,000	102,920	102,920	104	13.955%
12	ZGEB-BD-27/03/20-A0225-18	510	56,059,200	109,920	109,920	156	18.000%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дүти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
19	MMX	Мэхимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
23	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ERD: “Алтан нар”, “Баянхөндий” төслийн үнэлгээг IV улиралд гаргана

Монголын болон Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Erdene Resource Development” компани “Баянхөндий” төслийн анхдагч нөөцийн тайланг III улиралд танилцуулахаар төлөвлөж байна. Улмаар IV улиралд “Алтан нар”, “Баянхөндий” төслийн анхан шатны эдийн засгийн үнэлгээг гаргахаар зорьж байгаа талаар санхүүгийн тайландаа дурдлаа. Тус компани эдгээр гол ордууддаа хайгуулаас олборлолтын шат руу шилжихээр бэлтгэж байгаа юм. Оны эхний хагас жилд хайгуулын зардалд 3.1 сая канад доллар зарцуулсан нь жилийн өмнөхөөс 34 хувиар буурсан байна. Харин нэгж хувьцаанд ногдох цэвэр алдагдал 0.01 канад доллар болсон нь 2017 оны мөн үеэс хоёр дахин буурсан талаар санхүүгийн тайландаа дурджээ. “Erdene Resource Development” компани 6-р сард Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгүүлсэн юм. Тухайн үед анхдагч зах зээлийн захиалга даван биелж, 1.36 сая канад долларыг татсанаас гадна 4.12 сая канад долларыг хаалттай хүрээнд татан төвлөрүүлжээ.

8-р сарын 23-ны өдрийн арилжаагаар Торонтогийн Хөрөнгийн биржид нэгж хувьцааны ханш нь 0.36 канад доллар болж, өмнөх өдрийнхөөс 1.39 хувиар өсжээ. Харин баасан гарагт Монголын Хөрөнгийн биржид нэгж хувьцааг нь 594.13 төгрөгөөр арилжаалж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### “Сүү” ХК-ийн борлуулалтын орлого оны эхний хагаст 45.8 хувиар өсжээ

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй дотоодын үйлдвэрлэгч “Сүү” ХК-ийн борлуулалтын орлого энэ оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 45.8 хувиар өсжээ. “Сүү” ХК 2017 онд “Сүү” бонд гарган олон нийтээс зургаан тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд энэ оны 6-р сард бонд болон хүүг эргэн төлж нийт долоон тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдийнхээ дансанд байршуулсан юм.

Тус компани цаашид нэмэлт хувьцаа гаргах сонирхолтой байгаа талаар өмнө нь мэдээлж байв. Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, “ТОП-20” индексийн сагсанд багтдаг “Сүү” ХК-ийн хувьцааны ханш он гарснаас хойш 20 хувиар унаж, 209 төгрөг болоод байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Адуунчулуун” ХК-ийн цэвэр ашиг жилийн өмнөхөөс 40 гаруй хувиар буурав

“Адуунчулуун” ХК-ийн борлуулалтын орлого оны эхний хагас жилд 4.08 тэрбум төгрөг болсон талаар санхүүгийн тайландаа дурдсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс долоо орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Харин цэвэр ашиг нь 368.1 сая төгрөг болсон нь жилийн өмнөхтэй харьцуулахад 40 гаруй хувиар буурсан байна.

“Адуунчулуун” ХК нийт олборлосон нүүрснийхээ дийлэнх хэсгийг Дорнод бүсийн эрчим хүчний системд нийлүүлдэг. Энэ оны эхний хагас жилд тус компани 280 мянган тонн нүүрс борлуулсан нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй ойролцоо гарсан талаар мэдээллээ. Харин 2018 онд нийт 600 мянган тонн нүүрс борлуулахаар төлөвлөжээ.

“Адуунчулуун” ХК-ийн хувьцааны ханш 2018 он гарснаас хойш 26 хувиар буурч, хамгийн сүүлийн арилжаагаар 2200 төгрөг болоод байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Говь ХК: Олон улсад ноос, ноолуурын салбарын 61 хувийг эзэлж байна

Ноолуурын салбарт тэргүүлэгчдийн нэг “Говь” компанийн борлуулалтын орлого энэ оны эхний хагас жилд 55.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 64 хувиар өслөө. Тус компанийн борлуулалт ийнхүү өсөхөд гадаад борлуулалт 88 хувиар өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

“Говь” компани энэ оны эхний хагас жилд ӨМӨЗО, ХБНГУ болон БНТУ-д шинэ франчайз дэлгүүрүүдээ нээсэн байна. Мөн онлайн худалдааны сувгаа өргөжүүлж “Amazon”-оор дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж эхлээд байгаа ажээ. “Говь” компани 2018 оны эхний зургаан сарын байдлаар 13 орны 34 хотод таван салбар дэлгүүр болон 53 франчайз дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр тус компанийн гадаад зах зээлд ноос, ноолуурын салбарт эзлэх хувь хэмжээ нь 61 хувь болж тэлсэн талаар үйл ажиллагааны тайландаа тусгажээ. Тус компани зах зээлд эзлэх хувь хэмжээгээ улам тэлэхийн тулд 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байгаа аж.

Өнгөрсөн зургаадугаар сард Төв аймагт анхан шатны цогц үйлдвэрийн шав тавьсан байна. “Говь” компани 2017 оноос эхлэн БНХАУ-ын шинэ загварын самнах машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлж туршжээ. Шинэ машин үйлдвэрлэлд нэвтрүүлснээр эрчим хүчээ дөрөв дахин хэмнэхээс гадна, ажиллах хүч болоод чанарын үл тохирлыг бууруулсан талаар мэдээлж байна. Ингэснээр энэ онд нэмэлтээр таван шугам суурилуулжээ. Түүнчлэн Итали, Япон, Германы тоног, төхөөрөмжүүдийг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн байна.

200 орчим тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй “Говь” компани 2018 онд 18.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байгаа талаараа үйл ажиллагааны тайландаа тусгаж байсан юм. Харин оны эхний хагасын байдлаар 4.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байна.

Тус компанийн хувьцааны ханш II улирлын эцэст 24 орчим мянган төгрөг байсан нь жилийн дүнгээр 80 гаруй хувиар өссөн үзүүлэлт болж байгаа аж. ҮЦТХТ-ийн мэдээлснээр тус компанийн 84.2 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, 15.8 хувийг 16.2 мянган жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ҮСХ: Жоншны экспорт 45 хувиар өсөж, 79.3 сая ам.доллар болсон

2018 оны оны эхний долоон сард жоншны экспорт биет хэмжээгээр 45 хувиар өсөж, 239.9 мянган тонн хүрсэн бөгөөд мөнгөн дүнгээр 93 хувиар нэмэгдэж, 79.3 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Дээрх хугацаанд Монгол Улс нийт 20.8 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурсан байна. Харин мөнгөн дүнгээр тооцвол 15 хувиар өсөж, 1.6 тэрбум ам.доллар хүрсэн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Гол экспортлогч “Эрдэнэс Таван Толгой” ХК оны эхний зургаан сард 6.8 сая тонн нүүрс экспортолж, борлуулалтын орлого нь 953 тэрбум төгрөг, цэвэр ашиг нь 373.3 тэрбум төгрөг болсон талаар мэдээлжээ.

Мөн 848.1 мянган тонн зэсийн баяжмал экспортолсон нь жилийн өмнөхтэй ойролцоо байгаа ч мөнгөн дүнгээр 32.3 хувиар өсөж, 1.17 тэрбум ам.доллар болжээ. Гол экспортлогчдын нэг “Оюу Толгой” компанийн II улиралд үйлдвэрлэсэн баяжмал дахь зэсийн хэмжээ 1.5 хувиар нэмэгдэж, алтны үйлдвэрлэл 19 хувиар өссөн талаар “Turquoise Hill Resources” компани санхүүгийн тайландаа дурдсан байна. Үүнд борлуулалт, логистикийн үйл ажиллагаа тогтворжиж, I улиралд давагдашгүй хүчин зүйлийн улмаас хуримтлуулаад байсан баяжмалаа худалдан авагчдадаа нийлүүлсэн нь голлон нөлөөлсөн аж.

Харин төмрийн хүдрийн экспорт биет хэмжээгээр 24 хувиар өсөж, 3.9 сая тонн болсон ч мөнгөн дүнгээр дорвитой өөрчлөгдсөнгүй, 181.4 сая ам.доллар болсон байна. Мөн газрын тосны экспорт 10 гаруй хувиар буурч, 3.8 сая баррель болсноор мөнгөн дүнгээр 251 сая ам.доллар болсныг Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Барилга Эм Эн: Дотоодын үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдсэнээр импортын цементийн хэмжээ буурсан

Монгол Улс 2015 он хүртэл цементийн эрэлт, хэрэгцээний дийлэнхийг буюу 56-88 хувийг БНХАУ-аас импортолдог байсан бол 2015 онд цементийн импортын татварыг нэмэгдүүлж, мөндотоодын үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдсэнээр импортоор авдаг цементийн хэмжээ 17-25 хувь болтлоо буурсан талаар “Барилга Эм Эн” компани мэдээлж байна. Ингэснээр жилд гадагшаа урсдаг байсан 14-97 сая ам.доллар таван сая ам.доллар болтлоо буурчээ. Дотоодын цементийн борлуулалт 2013 онд 12 хувь байсан бол 2017 онд 80 хувь хүрч өссөн байна. Тухайлбал, 2015 онд жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Монполимет” компанийн “Монцемент” үйлдвэр, 860 сая тонны хүчин чадалтай “Мөнхийн Баян гал” компанийн цементийн үйлдвэр, мөн 2016 онд жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “МАК” компанийн “Хөх цавын цемент шохойн үйлдвэр” тус тус ашиглалтад орсноор цементийн хэрэгцээг дотоодын зах зээлээс хангах нөхцөл нэмэгджээ.

Монгол Улсад өөрийн өртөг, үйлдвэрийн хүчин чадлаасаа хамаарч нэг тонн цемент 84-105 мянган төгрөг байдаг тооцоо байдаг. Харин худалдаалах үнийн тухайд “Барилга Эм Эн”-ийн мэдээлснээр “Монцемент”-ийн цемент Улаанбаатар хотод тонн нь 160 мянган төгрөгөөр худалдаалагдаж байгаа бол “МАК” евро цемент 168 мянган төгрөгийн үнэтэй байгаа аж. Харин Хөтөлийн цемент “Барилгачин групп”-т тонн нь 170 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Өсөх зоос ХХК: Нүүрс угаах үйлдвэрээ 2019 онд ашиглалтад оруулна

БНХАУ-ын Засгийн газрын бодлоготой уялдуулж, Монголын нүүрс экспортлогчид нүүрсээ баяжуулан гаргахаар зорьж байна. Тухайлбал, Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж байгаа МАК, “Southgobi Sands”, “Өсөх зоос” компаниуд баяжуулах үйлдвэр байгуулахаар зорьж байгаа ажээ.

“Өсөх зоос” ХХК-ийн тухайд барилгын ажил нь үргэлжилж байгаа бөгөөд 2019 онд нүүрс угаах үйлдвэрээ ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа талаар тус компанийн Ерөнхий захирал Ч.Чинбат мэдээллээ. Баяжуулах үйлдвэрүүдийг бүрэн ашиглалтад оруулахад цахилгаан эрчим хүчний асуудал ихээхэн тулгамдаж байсан ч БНХАУ-аас импортлох байдлаар шийдвэрлэж байгаа гэдгийг эх сурвалж мэдээлсэн юм.

Харин “Southgobi Sands” компанийн баяжуулах үйлдвэрийн барилгын ажил бүрэн дуусаад байна. Жилд хоёр сая тонн нүүрс угаах хүчин чадалтай энэхүү үйлдвэрт F ангиллын нүүрсийг В ангилалд хүргэх боломжтой гэж тус компани мэдээллээ.

МАК-ийн хувьд жилд нэг сая тонн нүүрс угаах хүчин чадалтай үйлдвэрээ байгуулаад байна. Нүүрс баяжуулах явцад гүний ус биш, харин үерийн үеэр хуримтлагдсан нэг сая метр куб орчим усыг эхний жилүүдэд ашиглахаар төлөвлөж байгаа талаар МАК компани мэдээллээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Казахстаны нүүрсийг далайн боомтоороо экспортлохоос Орос татгалзжээ

Оросын уул уурхай, төмөрлөгийн үйлдвэрлэлийн “Мечел” компани энэ оны хоёрдугаар улирлын үйл ажиллагааны тайлангаа мэдээллээ. Тус мэдээллээр, Якут дахь Элгэгийн ордоос эрчим хүчний баяжуулсан нүүрсний экспортоо нэмэгдүүлэн анх удаа Энэтхэг, Мьянмар, Вьетнам улсын зах зээлд нийлүүлсэн байна. Ингэснээр тус компанийн Ази-Номхон далайн орнууд руу хийх нүүрсний экспорт 60%-иар өсчээ.

Түүнчлэн, коксжих нүүрсний баяжуулалтын үйлдвэрлэл нэмэгдсэн нь Хятад болон Япон улс руу чиглэсэн экспортын хэмжээ өссөнтэй холбоотой аж. Оны эхний хагас жилийн байдлаар, Элга ордын нүүрсний цогцолборт 3.52 сая тонн коксжих нүүрсийг баяжуулан экспортолжээ.

“Мечел” компани нь Хятадын “China Baowu Steel” группын бүрэлдэхүүнд багтах “Baosteel Resources” компанид нүүрс нийлүүлэх гэрээгээ дахин нэг жилээр буюу 2019 оны долдугаар сар хүртэл сунгаад байна. Гэрээний хугацаанд 700 мянган тонн коксжих нүүрс Хятадын талд нийлүүлэх юм.

Орос, Хятадын эдгээр компаниуд анх 2013 онд нүүрс нийлүүлэх урт хугацааны гэрээ байгуулж байсан бөгөөд жил бүр гэрээний хугацааг сунгадаг. Өнгөрсөн оны нэг жилийн гэрээгээр Оросын компани Элгэгийн ордоос 960 мянган тонн коксжих нүүрс “Baosteel Resources”-д нийлүүлсэн байна.

Оросын коксжих нүүрсний томоохон экспортлогч “Мечел” компани нийт 2 сая тонн коксжих нүүрс 2017 онд Хятадын зах зээлд экспортолжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn


## БУСАД МЭДЭЭ

### Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 320 мянган төгрөг боллоо

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сарын 320 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, 2019 оноос хэрэгжүүлэхээр болсныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг мэдээллээ. Ингэснээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2017 онд сүүлд шинэчилснээс 80 мянган төгрөгөөр нэмэгдэж байгаа юм. Цаашид 2020 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үргэлжлүүлэн нэмж, 420 мянган төгрөгт хүргэнэ гэдгийг Ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос онцолсон юм. Одоогоор нийт ажиллагсдын найман хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждаг байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жил тутам шинэчлэн тогтооно гэсэн хуультай. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоохдоо хэд хэдэн хүчин зүйлийг харсан. Нэг цагийн 1904 төгрөг, сард 320 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоож, 2019 оны нэгдүгээр сарын нэгнээс хэрэгжүүлэхээр боллоо. Улсын хэмжээнд 1.1 ажиллагсад байна. Эдгээр ажиллагсдын найман хувь буюу 80 мянган хүн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждаг” гэж мэдээллээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### ЗГ: Ирэх сараас төрийн албан хаагчдын цалинг 8-30 хүртэлх хувиар нэмнэ

Төрийн албан хаагчдын цалинг 9-р сараас 8-30 хувь хүртэл нэмэх шийдвэрийг Засгийн газар гаргалаа. Энэ нь 2014 оноос хойш анх удаа Төрийн албан хаагчдын цалинг нэмсэн шийдвэр болж байна. Засгийн газраас мэдээлснээр харьцангуй өндөр цалинтай буюу улс төрийн албан тушаалтан, шүүгч, прокурорын цалинг нэмэхгүй байхаар болжээ. Харин бага цалинтай Төрийн үйлчилгээний ажилтнуудын цалинг 30 хүртэл хувиар нэмэхээр байна.

2018 оны батлагдсан төсөвт 182 мянган Төрийн албан хаагчийн цалингийн зардал 1.7 их наяд төгрөг байсан юм. Энэ нь төсвийн урсгал зардлын 24 хувийг эзэлж байна. Цалингийн нэмэгдэлд энэ жилдээ 56 тэрбум төгрөг зарцуулахаар болсон байна. Ингэхдээ төсөвт тодотгол хийхгүй гэдгийг Засгийн газрын хэвлэлийн албанаас мэдээллээ. Мөн Төрийн албан хаагчдын цалинг царцаах агуулга бүхий УИХ-ын 29 дүгээр тогтоолыг цуцлуулах саналыг Засгийн газар УИХ-д өргөн барихаар болсон байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### СЯ: Төсвийн орлого 589 тэрбум төгрөгөөр давж биелсэн


Төсвийн орлого энэ оны долоодугаар сарын гүйцэтгэлээр 589 тэрбум төгрөгөөр давж биелээд байгааг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар мэдээллээ.

Ингэснээр төсвийн тэнцэл 291.3 тэрбум төгрөг болж, оны эхний долоон сарын байдлаар 2015 оноос хойш анх удаа ашигтай гараад байна.

Төсвийн орлого давж биелэхэд орлогын 80 орчим хувийг бүрдүүлдэг татварын орлого 33 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Татварын шинэчлэлээр НӨАТ-ын орлого 34.1 хувиар нэмэгдсэн бол онцгой албан татварын дүн хэмжээ нэмэгдсэнээр 68 хувийн өсөлт бий болсон байна.

Олон Улсын Валютын Сангаас “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн тав дахь шатны үнэлгээг хийхдээ багийн ахлагч Жэф Готлийб “Сүүлийн үеийн макро эдийн засгийн гүйцэтгэл эерэг байж, гол зорилтууд хангагдаж, эдийн засаг сайн сэргэж байгаа боловч тодорхой хэмжээний эмзэг байдал оршоор байна” гэдгийг онцолж байсан юм. Төсвийн орлого нэмэгдэж, эдийн засаг тааламжтай байгаа энэ үед Засгийн газар Төрийн албан хаагчдын цалинг 8-30 хувь хүртэл нэмэх шийдвэр гаргаад байна. Ингэхдээ төсөвт тодотгол хийхгүй. Ирэх жилээс жил бүр инфляцын түвшинтэй уялдуулж цалин нэмнэ гэж мэдээлсэн юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.